



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/55

Хэрлэн сум

Хүүхдийн чөлөөт цагийг үр ашигтай  
өнгөрүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Гайхамшигт хүмүүсийн дуу хоолой" Хэнтий аймгийн хүүхдийн чуулганаас гарсан саналыг хэрэгжүүлэх зорилгоор сургуулийн спорт заалыг насанд хүрэгчид, бусад байгууллагуудад төлбөртэй ашиглуулдаг үйл ажиллагааг зогсоож, 2023 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Политехник коллеж, ерөнхий боловсролын сургуулиудын урлаг, спорт заалыг хүүхдүүдэд хичээлийн бус цагаар үнэ төлбөргүй, нээлттэй ашиглуулах, хүүхдийн уралдаан тэмцээний үед заалыг нээлттэй байлгах орчин нөхцөлийг бүрдүүлэхийг Политехник коллеж болон ерөнхий боловсролын сургуулийн Захирлуудад үүрэг болгосугай.

2.Урлаг, спорт зааланд чөлөөт цагаа өнгөрөөхдөө сургуулиас баталсан журмыг баримтлан, эд хогшил, техник, тоног төхөөрөмжид ариг гамтай хандаж, үйл ажиллагаанд хамрагдах үедээ өөрийгөө болон бусад хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэхийг нийт хүүхдүүдэд уриалж, энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг сар бүр танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д даалгасугай

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



231010155